



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ПУНСАЛМАА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026. 01. 12 № ХЭГ/82
танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт *04* хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000265000629

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“5.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагаас санаачлан боловсруулсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагаас санаачлан боловсруулсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж, дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна” гэж заасан тул тогтоолын төслийн нэрийг “Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” гэж, үүнтэй уялдуулан тогтоолын төслийн 1, 2 дахь заалтын “улсын төсвийн” гэснийг “төсвийн” гэж тус тус өөрчлөх;


2.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтыг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа анх батлагдсан төсөвт өртөг нэмэгдсэн, төлөвлөсөн хугацаанаас удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан, үндэслэлийг тодорхойлж, цаашид төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлагатай эсэх мэдээллийг нэгтгэн боловсруулж, 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах” гэж, 1 дэх заалтын 2 дахь дэд заалтыг “Төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн боловч цаашид хэрэгжүүлэх шаардлагагүй төсөл, арга хэмжээг хувьчлах, дуудлага худалдаагаар худалдан борлуулах талаар холбогдох санал, дүгнэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах” гэж тус тус өөрчлөн найруулах;

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1, 3 дахь дэд заалтад тусгасан арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэх боломжтой тул эдгээр заалтыг нэгтгэх;

4.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 4, 5 дахь дэд заалтад тусгасан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээнд санал авах, эрэмбэлэх, үнэлэх, батлах үйл явцыг системчлэх болон гүйцэтгэлийн тоон мэдээллийн нэгдсэн сан үүсгэх зэрэг асуудлыг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх,

эрэмбэлэх, сонгох журам болон аргачлалууд”, 2023 оны 137 дугаар тушаалаар баталсан “Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал”-ын дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ээр дамжуулан хэрэгжүүлж байгаа тул дээрх заалтуудыг хасах;

5.Тогтоолын төслийг батлан хэрэгжүүлснээр гарах үр нөлөөний үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтад заасан аргачлалын дагуу боловсруулах, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.13 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн үзэл баримтлалд баталсан он, сар, өдрийг тусгах шаардлагатай.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР